



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



ТАНЫ ЭРҮҮЛ МЭНДЭД...



*Сүрьеэ өвчний эсрэг эмчилгээ
хийлгэж буй хүмүүст зориулав.*



Бэлтгэсэн: Б.Бодьцэцэг
Хянасан: С.Өнөрсайхан /Ph.D, НЭМҮТ эрдэмтэн, нарийн бичгийн дарга/
С.Гэрэлмаа /НЭМҮТ эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх албаны дарга/
Эхийг бэлтгэсэн: Ц.Сугар

Хаяг: Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг 6-р хороо
Бага тойруу 24-1
Монреимпекс байр 207 тоот
Утас: 11-311427

“Содпресс” ХХК-д хэвлэв.
Улаанбаатар хот, 2021 он.




Сүрьеэгийн халдвар



Сүрьеэ нь сүрьеэгийн нянгаар үүсгэгддэг халдварт өвчин юм. Энэ өвчнөөр хэн ч өвчилж болно. Учир нь ханиад томуу зэрэг өвчнүүдтэй адил амьсгалж буй агаараар дамжин халдварладаг. Сүрьеэгийн нян хүний биеийн аль ч эрхтнийг гэмтээж болох ч ихэвчлэн уушгийг өвчлүүлдэг байна.

*Сүрьеэ - амьсгалын замаар тархдаг халдварт өвчин
Халдвартай хэлбэрийн сүрьеэгээр өвчилсөн хүн - халдварын эх уурхай болно.*




Уушгины хэлбэрийн сүрьеэгээр өвчилсөн, цэрэнд нь сүрьеэгийн нян ялгарч байгаа хүн энэ өвчний халдварыг бусдад тараах эх уурхай нь болно. Эдгээр хүмүүс ярих, дуулах, ханиах, найтаах, нус цэрээ хаях үед сүрьеэгийн нянгууд агаарт цацагдана. Сүрьеэгийн нянгаар бохирлогдсон агаараар амьсгалсан хүмүүс сүрьеэгийн халдвар авдаг. Үүнээс үзвэл:

- » Сүрьеэгээр өвчилсөн хүний гэр бүлийнхэн, хамт ажилладаг хүмүүс, халдвар авах магадлал хамгийн өндөр юм.
- » Сүрьеэгийн нян аяга, таваг, өмссөн хувцас зэргээр дамжин халдварладаггүй.
- » Халдварт шар, бэлгийн замын халдварт өвчнүүдтэй харьцуулахад хувь хүн сүрьеэгийн халдварыг амьсгалж байгаа агаараар дамжуулан авдаг ч, сүрьеэгээр өвчлөх эсэх нь тухайн хүний хувийн ариун цэвэр, хооллолт, эрүүл ахуйн дадал, заншил зэрэгтэй холбоотой.

Сүрьеэгийн халдвар авсан гэдэг нь сүрьеэгээр өвчилснөөс ялгаатай юу?



*Таны биеийн эсэргүүцэл
сайн бол сүрьеэгээр
өвчлөхгүй байж болно.*



Нянгаар бохирлогдсон агаар амьсгалснаар сүрьеэгийн нянгууд хүний биед орно.






Хэрэв тухайн хүний биеийн эсэргүүцэл сайн бол нянгууд өвчин үүсгэхгүй унтаа байдалд шилжин хүний биед хадгалагдана. Ийм тохиолдлыг сүрьеэгийн **халдвар авсан** гэж хэлнэ.

Сүрьеэгийн халдвар авсан хүмүүст ямар нэг зовиур мэдэгдэхгүй, бусдад халдвар тараах аюулгүй бөгөөд насан туршдаа ч өвдөхгүй байж болно.

Сүрьеэгийн халдвар
авсан эсэхийг
сүрьеэгийн сорилоор
тодорхойлдог.

Хоол унд дутмаг байх,
сэтгэл санаагаар
унах, халдварт болон
халдварт бус өвчнөөр
өвчлөх, архи тамхи
хэрэглэх, ядрах, байнга
даарч хөрөх зэргээс болж
тухайн хүний биеийн
эсэргүүцэл сулрахад унтаа
байдалд байсан нянгууд
сэрж, эд эрхтнүүдийг
гэмтээж эхэлнэ.

Аливаа хүн өөрийн
Ажил амралтаа
зохицуулж, тогтмол
хооллож, архи тамхи
хэрэглэхгүй байвал биеийн
эсэргүүцэл сулрахгүй,
сүрьеэгээр өвчлөхгүй
байж болно.



Сүрьеэ ӨВЧНИЙ ШИНЖ ТЭМДЭГ

Хэрэв танд эдгээр шинж тэмдгүүд илэрвэл харьяа аймаг, дүүргийн сүрьеэгийн эмчид яаралтай хандаарай.



Та болон таны гэр бүлийнхэн, хамт ажилладаг хүмүүс, ойр дотныхонд дээрх шинж тэмдгүүд илэрвэл харьяа аймаг, дүүргийн эмнэлэгт очихыг зөвлөөрэй.

Мөн сүрьеэгийн нян нь хүний биеийн цус, тунгалгийн шингэнээр дамжин яс, булчирхай, тархи нугас, шээс ялгаруулах болон бэлэг эрхтний сүрьеэг үүсгэж болно. Эдгээрийг **уушгины бус эрхтний сүрьеэ** гэж нэрлэх ба энэ хэлбэрээр өвчилсөн хүн бусдад халдвар тараах аюулгүй юм.

ХҮҮХДИЙН СҮРЬЕЭ

Хэрэв та болон таны гэр бүлийнхний хэн нэг нь сүрьеэгээр өвчилсөн бол хүүхдүүд минь бас өвдөх болов уу гэж сэтгэл тань зовох нь зүйн хэрэг биз ээ. Хүүхэд эхээс төрөхдөө сүрьеэгийн халдварыг огт аваагүй төрдөг. Манай улсад хүүхдийг төрмөгц, сүрьеэ өвчнөөс сэргийлэх БЦЖ вакциныг төрөх тасагт хийдэг. Хэрэв таны хүүхэд энэ вакциныг хийлгэсэн бол зүүн гарын бугалганы дээд хэсэгт жижиг, цагаан сорви үүссэн байх учиртай. Энэ вакцины хамгаалах чадвар нь 6-7 жил байдаг тул 8 насанд дахин хийлгэх шаардлагатай.

Хүүхэд сүрьеэгийн халдвар авсан эсэхийг сүрьеэгийн сорилоор мэдэж болно. Энэ сорилыг тарьсны дараа 72 цаг болоод үүссэн гүвдрүүт хэмжиж хариуг тодорхойлно. Гүвдрүүний хэмжээ 5-11мм түүнээс дээш бол халдварлагдсан гэж үздэг. Гэхдээ халдварлагдсан болгон сүрьеэгээр өвчлөхгүй.

БЦЖ вакцин нь хүүхдийг сүрьеэгийн хүнд хэлбэрцүдээс найдвартай хамгаална.



Харин гүвдрүүний хэмжээ 11мм-ээс дээш гарвал сүрьеэгийн оношилгооны бусад шинжилгээг хүүхдэдээ заавал хийлгээрэй. Хүүхдийн биеийн эсэргүүцэл том хүнийхтэй харьцуулбал сул байдаг учраас хүнд хэлбэрийн сүрьеэгээр өвчлөх магадлал нь өндөр байдаг. Хүүхдүүд сүрьеэгийн халдварыг ойр дотны хүмүүс, хөршүүдээсээ авсан байдаг байна.

Сүрьеэгийн ОНОШИЛГОО, ШИНЖИЛГЭЭ



14 хоногоос дээш хугацаагаар ханиалгаж байгаа хүний цэрэнд сүрьеэгийн нян хайх шинжилгээ нь хамгийн найдвартай, хялбар шинжилгээ юм. Энэ шинжилгээг хийхийн тулд 24 цагийн дотор цэрийг 3 удаа тусгай саванд авна.

Шинжилгээг өгөхөөс өмнө амаа буцалгасан усаар зайлж, цээжний гүнээс хахирч ханиалган цэрээ гаргах хэрэгтэй. Цэр биш шүлс шинжилгээнд өгвөл шинжилгээний хариу буруу гарах болно гэдгийг анхаарах нь зүйтэй. Хэрэв цэрэнд сүрьеэгийн нян илэрвэл эмч “түрхэц эерэг” байна гэж хэлэх ба энэ нь та сүрьеэгээр өвчилсөн төдийгүй бусдад халдвар тараана гэсэн үг юм.

Цэрний шинжилгээг оношилгоонд хэрэглэхээс гадна таны эмчилгээ хэр үр дүнтэй байгааг хянах зорилгоор хяналтын шинжилгээг эмчилгээ эхэлснээс хойш 2, (3) 5, 6 дахь саруудад хийдэг.


Мөн гэрлийн шинжилгээ, ялангуяа хүүхдэд сүрьеэгийн сорилын шинжилгээг оношилгоонд хэрэглэж болно.



Цэрний түрхэцийн шинжилгээний арга нь халдвартай хэлбэрийн сүрьеэг илрүүлж, эмчилгээг хянах гол арга юм.

Сүрьеэгийн эмчилгээ

Сүрьеэгийн эмчилгээнд 5 эмийг хослуулан хэрэглэнэ. Эдгээр эмүүд сүрьеэгийн нянгийн эсрэг өөр өөрийн өвөрмөц үйлчилгээтэй байдаг учир хамтад нь зөв хослуулж хэрэглэвэл нянг устгаж, сүрьеэг эдгээнэ. Харин сүрьеэгийн эсрэг эмүүдийг өөр өвчнийг анагаах зорилгоор хэрэглэх нь сайн үр дүн үзүүлэхгүй бусад эрхтэн системд хортой нөлөө үзүүлнэ.



Сүрьеэгийн эсрэг эмийг эмч, эмнэлгийн ажилтны хяналтанд 6-8 сар эмчлэх аргыг шууд хяналттай богино хугацааны эмчилгээний арга гэдэг. Сүрьеэ өвчний эсрэг эмчилгээг хоёр үе шаттай хийдэг.

1. Эрчимт эмчилгээний шат. Энэ шатанд сүрьеэгээр өвчилсөн хүний өвчний үе шатаас хамааран 4-5 төрлийн эмийг 2-3 сарын хугацаанд хэрэглэнэ. Хэрэв эмчилгээг хяналттай, тасралтгүй эмчийн заавраар хийлгэсэн бол уушгины халдвартай хэлбэрийн сүрьеэгээр өвчилсөн хүмүүсийн 90% нь энэ хугацаанд халдвар ялгаруулахаа больдог.

2. Үргэлжлэх шатны эмчилгээ. Энэ шатанд 2 төрлийн эмийг 4-6 сарын хугацаанд хэрэглэнэ. Учир нь эмийн ариутгах үйлчилгээ нь сүрьеэгийн үлдсэн нянг устгаж, дахилтаас сэргийлнэ.

Сүрьеэгийн эсрэг ЭМЧИЛГЭЭНИЙ ОНЦЛОГ

*Богино хугацааны шууд
хяналттай эмчилгээ нь
сүрьеэтэй өвчтнийг эдгэрцүлж,
эмэнд дасалтай сүрьеэгээс
урьдчилан сэргийлж чадна.*

Эмчилгээг шууд
хяналттай хийдэгт оршино.
Энэ нь сүрьеэгээр өвчилсөн
хүн эмч, эмнэлгийн
ажилтны хяналтанд эмээ
уухыг хэлнэ. Эдгээр

хүмүүст туслах зорилгоор эрүүл мэндийн сайн дурын ажилтнууд
эмийг өдөр бүр гэрт нь хүргэж өгөх ажлыг гүйцэтгэдэг. Ингэснээр
сүрьеэгийн эсрэг эмүүдийг тохирох тунгаар, зохих хугацаанд нь
тасралтгүй тогтмол уухын баталгаа болж өгдөг юм. Учир нь сүрьеэтэй
өвчтөний эмчилгээ нь удаан хугацаагаар үргэлжлэх шаардлагатай
боловч ихэнх хүмүүс эмээ өдөр бүр тогтмол ууж чаддаггүй. Мөн
сүрьеэгээр өвчилсөн хүн эмчилгээний эхний үед эмээ эрчимтэй ууж
байснаа өөрт мэдэгдэх зовиур алга болох үед эдгэрчихлээ гэж бодож
эмээ уухаа больчихдог. Гэвч үнэн хэрэгтээ энэ бол зөвхөн нянгийн
идэвхтэй байдлыг дарж байгаа эмийн үйлдлийн эхний нөлөө.

Хэрэв эмчилгээг цаашид тасралтгүй үргэлжлүүлбэл, сүрьеэ
өвчин эдгэрэх бөгөөд харин эмийн үйлдлийн эхний нөлөөнд хууртан
эмчилгээг дутуу орхивол сүрьеэгийн нянгууд нь эмэндээ дасаад
зогсохгүй тодорхой хугацааны дараа өвчин хүндэрч дахина. Энэ үед
хэдий эмчилгээг тогтмол тасралтгүй, эмчийн хяналтанд уусан нь
нэгэнт нян эмэнд дассан байдаг учир эмчилгээ нь үр дүнгүй болж,
улмаар тэр хүний эрүүл мэнд, амь насанд аюул учирч болзошгүй
тул сүрьеэгийн эсрэг эмчилгээг эмийн зааврын дагуу хяналттай,
тасралтгүй хийлгэж, энэ өвчнөөс бүрэн ангижрах хэрэгтэй.

Та сүрьеэгээр ӨВЧИЛСӨН ТОХИОЛДОЛД

Хэрэв та халдвартай хэлбэрийн сүрьеэгээр өвчилсөн бол хамгийн түрүүнд гэр орныхон, хамт ажиллагсад болон бусдад халдвар тараахгүй байх нь чухал. Энэ нь эрчимт шатны эмчилгээг эмнэлэгт хэвтэж хийлгэнэ гэсэн үг юм. Мөн таны ханиах, найтаах үед сүрьеэгийн нянгууд агаарт цацагдаж байдаг учир ханиаж найтаахдаа ам хамраа дарж занших, нус цэрээ ил задгай хаяхгүй байх нь халдвар тараахгүй байх нэг арга болно. Сүрьеэгээр өвчилсөн үед аль болох илчлэг ихтэй хоол, ялангуяа амин дэм агуулсан жимс, ногоо, цагаан идээ тохиромжтой бөгөөд өөр бусад өвчний улмаас харшлах зүйлгүй бол хоолны талаас хориглох зүйлгүй. Сүрьеэ өвчин нь ихэвчлэн уушгийг гэмтээдэг тул тамхи татаж тамирдсан уушгийг улам хордуулах хэрэггүй биз ээ.

Эмчилгээ хийлгэх явцад архи уувал эмийн гаж нөлөө илэрч эмчилгээ үр дүнгүй болно. Ингэвэл та эдгэх боломжоо алдаж магадгүйг анхаараарай.



*Таны бие сайжирч халдвар
ялгаруулахаа больсон бол
ажилдаа эргэн орж болно.*

Сүрьеэгээр өвчилсөн хүн эмчилгээ хийлгэж байх хугацаандаа 156 хоног хүртэл эмнэлгийн хуудас авах эрхтэй ба халдвар ялгаруулахаа

больсон буюу эдгэрсэн үед урьд нь хийж байсан ажилдаа эргэн орж болно. Архаг хэлбэрийн сүрьеэгийн улмаас мэс засал хийлгэж, хөдөлмөрийн чадвар алдсан тохиолдолд тахир дутуугийн группд оруулдаг.



Таны анхааралд:

- * Өөрийн ойр дотны хүмүүсийнхээ эрүүл мэндийн тусын тулд тэднийг урьдчилан сэргийлэх үзлэгт заавал хамруулах,
- * Сүрьеэ өвчинг бүрэн эдгээхийн тулд нэг ч өдөр эмээ таслахгүй, мартажгүй байх,
- * Ямар нэг шалтгаанаар урт, богино хугацаагаар чөлөө авч эмчилгээг сунгахгүй байх,
- * Таны үргэлжлэх шатны эмийг өдөр бүр гэрт тань хүргэн өгч, харж уулгаж байгаа эрүүл мэндийн сайн дурын ажилтнуудын таны төлөө гэсэн сэтгэлийг хүндэтгээрэй.

**Өөрийн эрүүл мэндэд
анхаарал тавьсан танд баярлалаа.**

